



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн тооллогын комиссын №02 тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. 2022 онд компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ЦОГТ



Бүрэлдэвчтэйг +976 7010-7790
Диагностик хэлэлцээг +976 8000-1900



www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 болон 77.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:
 1. Огай Н.Ю.
 2. Громов С.Б.
 3. О.Эрдэнэбулган
 4. Л.Таня
 5. С.Тэнгис
 6. Громов Б.С.
3. Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:
 1. О.Цогт
 2. Б.Аюуш
 3. Б.Энхтуяа
4. Компанийн эрх ашгийг дээдлэн, Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ЦОГТ



Буюуно даатгал +976 3010-1990
Даатгалын өмөлх +976 1800-1990



www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн тооллогын комиссын №02 тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг хавсралт №01-ээр баталсугай.
2. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ЦОГТ



Бүрэлдэвч даатгал: +976 7010-1990
Даатгалын гэрээг: +976 1800-1990



www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний №03 тоот тогтоолын хавсралт №01



КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ХУРЛЫН ТӨСӨВ

№	Ангилал	Нийт төсөв, ₮
1	ТУЗ-ийн гишүүдийн цалин	20,160,000
2	ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлын цалин	3,200,000
3	Эчнээ санал хураалтын цалин	4,800,000
4	Хурлын бусад зардал	1,000,000
-	Нийт дүн	29,160,000



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ
НЬ:

1. Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1. болон 7.22 дах хэсэгт өөрчлөлт оруулж, 7.52 дах хэсэг 7.52.1, 7.52.2, 7.52.3 заалтууд, 7.53, 7.54, 7.55 хэсгийг хавсралтад завснаар нэмэж оруулсугай.
2. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Хууль, эрх зүй хариуцсан захирал /Т.Наранцогт/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ЦОГТ



Булвиг дараах: +976 7010-1990
Даатгалын гэрээг: +976 1800-1990



www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn



"Монгол Даатгал" ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт			
№	Одоогийн мөрдөгдөж буй дүрмийн заалт	Оруулах нэмэлт, өөрчлөлт	Тайлбар
1	7.1 ...Хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэр болон хурлын тэмдэглэлийг баталгаажуулах, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлыг компанийн ТУЗ-өөс баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулдах журам"-аар зохицуулна.	7.1 ...Хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэр болон хурлын тэмдэглэлийг баталгаажуулах, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлыг компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулдах журам"-аар зохицуулна.	"Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулдах журам"-ыг компанийн ТУЗ-өөс батлах нь компанийн засаглалын хувьд тохиромжгүй байх тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлах нь зүйтэй байна.
2	7.22 Компанийн ТУЗ нь үйл ажиллагааныхаа үр өгөөжтэй, мэргэшсэн, хараат бус байдлыг хангах зорилгоор байнгын болон түр хороо байгуулж болно. ТУЗ нь Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна.	7.22 Компанийн ТУЗ нь үйл ажиллагааныхаа үр өгөөжтэй, мэргэшсэн, хараат бус байдлыг хангах зорилгоор байнгын болон түр хороо байгуулж болно. ТУЗ нь Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын, Даатгалын хороотой байна. Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын хорооны гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна. Харин Даатгалын хорооны гишүүд нь ТУЗ-ийн ердийн гишүүд байж болно.	Компанийн тухай хуулийн 81.1-д "Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно." гэж заасны дагуу компанийн даатгалын үйл ажиллагааг үр ашигтай явуулах зорилгоор Даатгалын хороог шинээр байгуулах шаардлагатай байна.



3	* Нэмсэн заалт	<p>Даатгалын хороо 7.52. ТУЗ нь даатгалтай холбоотой энэ зүйлд заасан үйл ажиллагааг Даатгалын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ. Даатгалын хороо нь дараах чиг үүрэгтэй байна.</p> <p>7.52.1. Өндөр үнийн дүнтэй болон компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий даатгалын нөхөн төлбөрийн асуудлыг хянах, шийдвэрлэх эрхтэй.</p> <p>7.52.2. Өндөр үнэлгээтэй болон компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий даатгалын гэрээг хянах, гэрээг байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэх эрхтэй.</p> <p>7.52.3. Даатгалын хороо, түүний гишүүд нь шаардлагатай гэж үзвэл компанийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлаар санал гаргах эсхүл гүйцэтгэх удирдлагын гаргасан саналын үндсэн дээр асуудлыг хэлэлцэх эрхтэй.</p> <p>7.53 Энэхүү дүрмийн 7.52-д заасан өндөр үнийн дүн, өндөр үнэлгээ болон компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий даатгалын гэрээ, даатгалын нөхөн төлбөрийн асуудлыг Даатгалын хороо өөрөө тодорхойлно.</p> <p>7.54 Даатгалын үйл ажиллагаатай холбоотой эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэрийн талаар ТУЗ-д тайлагнах үүрэгтэй.</p> <p>7.55 ТУЗ-ийн хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох дотоод дүрэм, журмаар зохицуулна.</p>
---	----------------	--

Жич: Эдгээр өөрчлөлтийг оруулсан дүрмийг "Монгол даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэмэлт өөрчлөлт оруулан батлав" гэсэн тодотголтойгоор улсын бүртгэлд бүртгүүлнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ